



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн
газар байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий “Чингэлтэй дүүргийн Теле камерын хяналтын дэд төв” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байгуулсугай.

2. “Чингэлтэй дүүргийн Теле камерын хяналтын дэд төв” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3. Батлагдсан дүрмийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

4. “Чингэлтэй дүүргийн Теле камерын хяналтын дэд төв” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зардлыг жил бүрийн төсөвт тусгуулан, хэрэгжилтийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

D:/2025-togtool

1150100025

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 03 дугаар сарын 18-ны
өдрийн 09 дугаар тогтоолын хавсралт

“ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ТЕЛЕ КАМЕРЫН ХЯНАЛТЫН ДЭД ТӨВ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.“Чингэлтэй дүүргийн Теле камерын хяналтын дэд төв” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь улс, нийслэл, дүүргээс баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг бүхий өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүжиж, ажил үйлчилгээ эрхлэх орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байна.

1.2.“Чингэлтэй дүүргийн Теле камерын хяналтын дэд төв” ОНӨТҮГ (цаашид “Теле камерын хяналтын дэд төв” гэх) нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Иргэний хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үйл ажиллагааны хөтөлбөр болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3.Энэхүү дүрмийн зорилго нь “Теле камерын хяналтын дэд төв”-ийн дүрмээр олгогдсон үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, төсөвт үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.4.Оноосон нэр нь “Чингэлтэй дүүргийн Теле камерын хяналтын дэд төв” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байх ба товчилсон нэр нь “ЧДТКХДТ” ОНӨТҮГ байна.

1.5.“Теле камерын хяналтын дэд төв”-ийн албан ёсны хаяг нь: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 22 дугаар хороо, Согоотын 83 гудамж.

1.6.“Теле камерын хяналтын дэд төв”-ийн өмчлөгч нь Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар байх бөгөөд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч нь “Теле камерын хяналтын дэд төв” ОНӨТҮГ байна.

**Хоёр.Теле камерын хяналтын дэд төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл,
үйл ажиллагаа явуулах хугацаа**

2.1.“Теле камерын хяналтын дэд төв” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа дараах чиглэлийн хүрээнд явуулна. Үүнд:

2.1.1.Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд суурилуулсан теле камеруудыг нэгтгэх, хяналт тавих, бичлэг хадгалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх авто замын хөдөлгөөний зохицуулалт хийх төрийн байгууллагуудад шаардлагатай дүрс бичлэгийг харуулах нэгдсэн удирдлага зохицуулалт хийх, төрийн албадыг мэдээ мэдээллээр хангах;

2.1.2.Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг камержуулах, суурилуулсан теле камеруудыг нэгтгэх, камеруудын хамгаалалт, арчлалт, засвар үйлчилгээг хариуцан, хэвийн ажиллагааг хангах;

2.1.3.Теле камерын дүрст мэдээллийг ажиглах, боловсруулах;

2.1.4.Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудад шаардлагатай дүрс бичлэгийг харуулах, нэгдсэн удирдлага зохицуулалт хийх, холбогдох байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;

2.2.“Теле камерын хяналтын дэд төв” нь гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай энэхүү дүрмийн хүрээнд харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, түүнчлэн хуулийн дагуу нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр татагдаж болно.

2.3.Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр Теле камерын хяналтын дэд төвийг өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

Гурав.Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын удирдлага, бүтэц, зохион байгуулалт

3.1.“Теле камерын хяналтын дэд төв”-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог дүүргийн Засаг дарга батална.

3.2.“Теле камерын хяналтын дэд төв”-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэвийн үйл ажиллагааг хангаж хяналт тавих, чиг үүргийг “Теле камерын хяналтын дэд төв”-ийн дарга хэрэгжүүлнэ.

3.3.“Теле камерын хяналтын дэд төв”-ийн даргыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу дүүргийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

3.4.“Теле камерын хяналтын дэд төв”-ийн даргын эзгүйд түүний эрх, үүргийг томилогдсон эрх бүхий этгээд гүйцэтгэнэ.

3.5.“Теле камерын хяналтын дэд төв” нь үйл ажиллагаагаа дүүргийн Засаг даргын ерөнхий удирдлага дор явуулж, түүнд ажлаа тайлагнана.

Дөрөв.Теле камерын хяналтын дэд төвийн дарга

4.1. "Теле камерын хяналтын дэд төв"-ийн өдөр тутмын үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрэм болон дүүргийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд нийцүүлэн түүний дарга удирдан зохион байгуулах бөгөөд Теле камерын хяналтын дэд төвийн даргыг (цаашид "Төвийн дарга" гэх) дүүргийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.2. Төвийн дарга нь орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг давхар хавсран гүйцэтгэхийг хориглоно.

4.3. Төвийн дарга нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан байна.

4.4. Төвийн дарга нь дүүргийн Засаг дарга, эрх бүхий байгууллагаас олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах бөгөөд эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

4.5. Төвийн дарга нь дүүргийн Засаг даргатай үр дүнгийн болон контракт гэрээ байгуулж, биелэлтийг дүгнүүлэн ажиллана. Төвийн даргын эдлэх эрх, хүлээх хариуцлага, цалин хөлс, урамшуулал зэрэг асуудлыг дүүргийн Засаг даргатай байгуулах гэрээнд тодорхой тусгана.

4.6. Төвийн дарга нь дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

4.6.1. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд "Теле камерын хяналтын дэд төв"-ийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

4.6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй "Теле камерын хяналтын дэд төв"-ийн хэвийн ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

4.6.3. "Теле камерын хяналтын дэд төв"-ийн эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчилж үр бүтээмжтэй ажиллах;

4.6.4. Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

4.6.5. Дүүргийн Засаг даргын баталсан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажилд авах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх;

4.6.6. "Теле камерын хяналтын дэд төв"-ийг мэргэжлийн чадварлаг хүний нөөцөөр хангаж, тэднийг сургаж бэлтгэх, дадлагажуулах, нийгмийн

асуудлыг шийдвэрлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;

4.6.7.“Теле камерын хяналтын дэд төв”-ийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх, үндсэн хөрөнгийн асуудлыг нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт уламжилж шийдвэрлүүлэх;

4.6.8.Холбогдох хуульд заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд төсвийг захиран зарцуулах;

4.6.9.Хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх үүргийг хэрэгжүүлэх;

4.7.Төвийн дарга хууль тогтоомж болон дүүргийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь ажлаас чөлөөлөх үндэслэл болно.

Тав.“Теле камерын хяналтын дэд төв”-ийн бэлгэдэл, тэмдэг

5.1.“Теле камерын хяналтын дэд төв” нь өөрийн бэлгэдэл, тэмдэгтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

5.2.Тамга, тэмдгээр “Теле камерын хяналтын дэд төв”-ийн албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

5.3.Тамга, тэмдгийг хууль журмын дагуу хариуцсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцах болно.

Зургаа.“Теле камерын хяналтын дэд төв”-ийн эд хөрөнгийн эрх, үүрэг

6.1.“Теле камерын хяналтын дэд төв” нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр доорх эрх эдэлж, үүрэг хариуцлага хүлээнэ. Үүнд:

6.1.1.Өөрт олгогдсон үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах, түрээслэх;

6.1.2.Үндсэн хөрөнгийг дүүргийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээгээр олгосон эрх хэмжээний хүрээнд эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

6.1.3.“Теле камерын хяналтын дэд төв” нь үндсэн хөрөнгийг зөвхөн дүүргийн эд хөрөнгийн ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн олж авах, акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх эрхтэй.

6.2.“Теле камерын хяналтын дэд төв” нь өөрийн өмчийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллана.

Долоо.“Теле камерын хяналтын дэд төв”-ийн хяналт

7.1. "Теле камерын хяналтын дэд төв" нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналт, үнэлгээ шинжилгээний ажилтантай байна.

7.2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу "Теле камерын хяналтын дэд төв"-ийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын дүгнэлт гаргуулна.

7.3. "Теле камерын хяналтын дэд төв"-ийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс хяналт тавьж ажиллана.

7.4. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

Найм. "Теле камерын хяналтын дэд төв"-ийн санхүү, бүртгэл, тайлан

8.1. "Теле камерын хяналтын дэд төв" нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

8.2. "Теле камерын хяналтын дэд төв"-ийн санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг дарга, нягтлан бодогч нар хариуцна.

8.3. "Теле камерын хяналтын дэд төв"-ийн нягтлан бодогч нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх бөгөөд түүнийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэстэй зөвшилцсөний үндсэн дээр томилж чөлөөлнө.

8.4. "Теле камерын хяналтын дэд төв"-ийн санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

8.5. "Теле камерын хяналтын дэд төв"-ийн орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

8.5.1. Дүүргийн төсвийн санхүүжилт

8.5.2. Байгууллагатай хамтран ажиллах гэрээний дагуу олсон үйлчилгээний орлого

8.5.3. Хандив, тусламж

8.5.4. Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

8.6. "Теле камерын хяналтын дэд төв"-ийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана. Үүнд:

8.6.1. Баланс

8.6.2.Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан

8.6.3.Мөнгөн гүйлгээний тайлан

8.6.4.Өмчийн өөрчлөлтийн тайлан

8.6.5.Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин, шагнал урамшуулал

8.6.6.Байгууллага, иргэд, ажилтнаас авах авлага, тэдгээрийн үүссэн шалтгаан, барагдуулалтын явц

8.6.7.Нэмэлт тайлбар

8.6.8.Санхүүгийн тайлангийн тодруулга

8.6.9.Бусад

8.7.Төвийн дарга нь дүүргийн Өмч хамгаалах зөвлөлд тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан тайлан, илтгэх бичиг хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана. Үүнд:

8.7.1.Тайлант хугацаанд “Теле камерын хяналтын дэд төв”-ийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;

8.7.2.Тайлант хугацаанд “Теле камерын хяналтын дэд төв”-ийн албан тушаалтан, ажиллагсдад олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээ;

Ес. “Теле камерын хяналтын дэд төв”-ийн бичиг баримтыг хадгалах

9.1. “Теле камерын хяналтын дэд төв” нь дараах бичиг баримтыг хадгална. Үүнд:

9.1.1. “Теле камерын хяналтын дэд төв”-ийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдох байгууллагуудын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ, сертификатууд;

9.1.2. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмжүүд;

9.1.3. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;

9.1.4. Үйлдвэрлэл, технологи, норм нормативууд, түүнтэй холбогдох дүрэм, журам, заавар, бусад бичиг баримт;

9.1.5.Хурлын тэмдэглэл, шийдвэр, тушаал;

9.1.6.Тухайн байгууллагын ирсэн, явуулсан албан бичиг;

9.1.7.Нийслэлийн Архивын газрын ББНШАЗК-ын хурлаар батлагдсан газрын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт болон тухайн байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуух ач холбогдол бүхий баримт бичгүүд;

9.2.Дээрх бичиг баримтуудыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах архивд шилжүүлэх зэрэг ажлын бичиг хэргийн эрхлэгч гүйцэтгэнэ.

Арав."Теле камерын хяналтын дэд төвийг татан буулгах

10.1."Теле камерын хяналтын дэд төв"-ийг дүүргийн Засаг даргын саналаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд тус тус заасны дагуу дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

Арван нэг.Хариуцлага

11.1.Төвийн дарга нь Монгол Улсын хууль тогтоомж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, дүүргийн Засаг даргын захирамж, шийдвэрийг биелүүлээгүй, энэхүү дүрмээр болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, буруу шийдвэр гаргасан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

11.2.Төвийн дарга нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж байгууллагад хохирол учруулсан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээж, хохирлыг бүрэн хариуцна.

Арван хоёр. Бусад

12.1.Энэхүү дүрэмд тусгаснаас бусад асуудлыг холбогдох хууль тогтоомж, гэрээгээр зохицуулна.

12.2.Энэхүү дүрмийн нэмэлт өөрчлөлт нь түүний салшгүй хэсэг байх бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг тухайн байгууллага бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдаж, дүүргийн Засаг даргад санал хүргүүлсний дагуу дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

12.3."Теле камерын хяналтын дэд төвийн дүрэм нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.